

## СПОРТЫН ТӨВ ОРДНООР ҮЙЛЧЛҮҮЛСЭН ИРГЭДИЙН СУДАЛГАА

/2023 оны 03 дугаар сарын байдлаар/

Спортын төв ордон нь 1958 онд спортын тэмцээн зохион байгуулах, бэлтгэл-дасгалжуулалтын үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан. Өнөөдрийн байдлаар уг ордонд төрийн захиргааны байгууллага болох Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хороо, Олимп, нийтийн биеийн тамирын үндэсний хорооны ажлын алба, Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургууль, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв, Үндэсний шигшээ багийн зарим холбоод, тамирчдын сургалт-дасгалжуулалт тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Засгийн газрын  
тохируулагч  
агентлаг-Биеийн  
тамир, спортын  
улсын хороо

Спортын анагаах  
ухаан, эрдэм  
шинжилгээний  
төв

Нийслэлийн  
ерөнхий  
боловсролын  
спортын төв  
сургууль

Олимп, нийтийн  
биеийн тамирын  
үндэсний  
хорооны ажлын  
алба

Үндэсний  
шигшээ багийн  
зарим спортын  
холбоод


ҮШБ болон  
бусад  
тамирчдын  
сургалт-  
дасгалжуулалт

### Биеийн тамир, спортын улсын хороо:

Тус байгууллагад төрийн захиргааны болон үйлчилгээний 48 албан хаагч ажиллаж байна. Тус байгууллагатай уулзахаар гаднаас ирсэн хүний тоо сард дунджаар 450 хүн гэж тооцов. Биеийн тамир, спортын улсын хороо нь иргэдэд хандсан төрийн үйлчилгээ үзүүлдэггүй болно.

Түүнчлэн, Спортын төв ордны харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээг 2019 оноос хойш бусдаар гүйцэтгүүлж байгаа бөгөөд нийт 4 харуул, 11 үйлчлэгч нийт 15 ажилтан ажиллаж байна. Эдгээр 11 үйлчлэгч нь 12000м<sup>2</sup> талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцдаг бөгөөд 1 үйлчлэгчид 1090м<sup>2</sup> талбайг хариуцдаг бөгөөд нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээнээс 1 дахин илүү талбайг цэвэрлэж байна.

Биеийн тамир, спортын улсын хорооны хүний хөдөлгөөний тоо (ажлын 22 өдрийн дунджаар тооцов)




■ Албан хаагч, ажилтан-1386  
■ Үйлчлүүлэгч450



## **Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв:**

Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн ажилтны тоо 21 ба тус төвөөр 03 дугаар сард тамирчид 839, ахмад тамирчид 651, бусад үйлчлүүлэгч 258 нийт 1748 хүн үйлчлүүлсэн байна.



Засгийн газрын 2020 оны 136 дугаар тогтоолоор “Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв” улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулагдаж мөн үеэс тус ордонд байршиж үйл ажиллагаа явуулж байна.

## **Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургууль:**

Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төрөлжсөн сургалттай дунд сургууль тус ордонд 2009 оноос хойш тасралтгүй байрлан сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаагаа явуулж байна. Тус сургуульд 448 сурагч суралцаж, багш, дасгалжуулагч 52 хүн ажиллаж байна. Ажлын 22 хоногоор тооцвол 03 дугаар сард тус сургуулийн үйл ажиллагаанаас шалтгаалан 11,000 хүний хөдөлгөөн үүссэн байна.

## **Олимп, нийтийн биеийн тамирын үндэсний хорооны ажлын алба:**

Олимп, нийтийн биеийн тамирын үндэсний хорооны ажлын алба нь нийт 5 албан хаагчтай бөгөөд ажлын 22 хоногоор тооцоход 110 хүний хөдөлгөөн үүссэн байна.

## **Үндэсний шигшээ багийн зарим спортын холбоод:**

Тус спортын ордонд жүдо, чөлөөт, бокс, хүндийн өргөлт, гимнастик, таеквондо, жюү-жицү, дугуй, биатлон, паралимпийн нийт 10 холбоод тус тус үйл ажиллагаа явуулж байна.


## **Үндэсний шигшээ багийн болон бусад тамирчдын сургалт-дасгалжуулалт:**

Спортын төв ордонд 5 спортын холбоо секц, дугуйлан сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- ✓ Жүдо бөхийн сургалт-дасгалжуулалтад 1170 тамирчид хамрагдаж, 15 дасгалжуулагч;
- ✓ Чөлөөт бөхийн сургалт-дасгалжуулалтад 164 тамирчин, 6 дасгалжуулагч;



- ✓ Самбо бөхийн сургалт-дасгалжуулалтад 21 тамирчин, 6 дасгалжуулагч;
- ✓ Хүндийн өргөлтийн сургалт-дасгалжуулалтад 168 тамирчин, 5 дасгалжуулагч;
- ✓ Боксын сургалт-дасгалжуулалтад 28 тамирчин, 6 дасгалжуулагч тус тус байна.



Нийт 5 секц, дугуйланд 1589 тамирчин, дасгалжуулагчид байгаагаас эзлэх тоо хувиар харьцуулан үзэхэд Жудо бөх 1185 буюу 74%, чөлөөт бөх 170 буюу 11%, Самбо бөх 27 буюу 2%, хүндийн өргөлт 173 буюу 11%, бокс 34 буюу 2%-г тус тус эзэлж байна.

Долоо хоногт 2 удаа сургалт-дасгалжуулалтад хамрагдсан гэж тооцвол 3 сард 12712 хүний хөдөлгөөн тус ордонд сургалт-дасгалжуулалт хийхээр ирсэн байна.

### Спортын төв ордны “А” заалаар үйлчлүүлэгчид:

Спортын төв ордны “А” зааланд 2023 оны 03 сард нийт Улсын аварга шалгаруулах тэмцээн 4 удаа зохион байгуулагдан 8200 хүн, лигийн тэмцээн 2 удаа зохион байгуулагдан 1800 хүн, бусад тэмцээнүүд 1 удаа зохион байгуулагдан 1000 хүн тус тус үйлчлүүлж, нийт дүнгээр 11.000 гаруй хүн үйлчлүүлжээ.



Тэмцээний 58 хувийг улсын аварга шалгаруулах тэмцээн, 25 хувийг лиг, 7 хувийг бусад тэмцээн эзэлж байна.



## Дүгнэлт:

Спортын төв ордонд байрлаж үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын нэгдсэн дүнгээр 03 дугаар сард үүссэн хүний хөдөлгөөнийг нэгтгэн танилцуулбал:

Биеийн тамир, спортын улсын хороо-1836

Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв-2210

Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургууль-11000

Ажлын алба-110

Сургалт-дасгалжуулалт-12712

“А” заалны үйл ажиллагаа-11000 нийт 38,868 хүний хөдөлгөөн үүссэн байна.



Сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаа 12712 хүн буюу 33 хувийг, Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургууль, А заалны үйлчилгээ тус тус 28 хувийг эзэлж байна.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт “Монгол Улсын олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрт зааснаас бусад тохиолдолд үндсэн үйл ажиллагаатай нь холбоо бүхий үйлчилгээ үзүүлдэг байгууллага, аж ахуйн нэгжээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг агентлагийн байранд байрлуулах”-ыг хориглодог. Гэтэл тус байранд нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургууль 2009 оноос хойш байрлан сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаагаа явуулж байна. Ерөнхий боловсролын сургууль нь гадаад болон дотоод орчны стандартын шаардлага хангахгүй зориулалтын бус байранд 450 сурагчид сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүсгэж байна.

Тодруулбал, Спортын төв ордны байрыг Монгол Улсын Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2012 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Барилгын төлөв байдлын тухай” 07-11/542 дугаар дүгнэлтээр “спортын ордны барилгыг цаашид ашиглалтын шаардлага хангахгүй” гэж тодорхойлсон. Түүнчлэн Монгол улсад 2021 оны 08 сарын байдлаар 39,786 газар хөдлөлт бүртгэгдэж 3,5 магнитудаас дээш хүчтэй газар хөдлөлт 36 удаа тохиосноос 19 газар хөдлөлт нь иргэдэд мэдрэгдсэн байна

Спортын төв ордон нь 1958 онд спортын тэмцээн зохион байгуулах, бэлтгэл-дасгалжуулалтын үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан хэдий ч одоогоор Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургууль байрлан сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаа явуулснаар зориулалтын дагуу бүрэн ашиглах боломжгүй болсон.

Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Спортын төв ордон”, “Нийслэлийн спортын сургалттай дунд сургууль”-ийг тус тус барьж байгуулахаар төлөвлөсөн байна.

Нийслэлийн спортын сургалттай дунд сургуулийн барилгын ажилд 2023 оны улсын төсөвт хөрөнгө суугдаагүй, Спортын төв ордон барих ажлыг Гадаадын зээл, тусламж буюу БНХАУ-ын буцалтгүй тусламжаар барьж байгуулахаар төлөвлөсөн хэдий ч одоогоор баригдаж эхлээгүй байна.

Санал:

- 1.Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургуулийг нүүлгэх;
- 2.Нийслэлийн спортын сургалттай дунд сургуулийн барилгын ажлыг эхлүүлэх;
- 3.Спортын төв ордон шинэчлэх ажлыг эхлүүлэх;
- 4.Цэвэрлэгээ, үйлчилгээний жилийн төсвийг нэмэгдүүлэх.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР